



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/401

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын а, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг, аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/240 дүгээр захирамжаар батлагдсан “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалт болон улсын төрөлжсөн олимпиадын амжилтыг харгалзан урамшуулал олгох журам”-ын 2.2.5, 2.2.6, 4.1, 4.2, 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалт болон улсын төрөлжсөн олимпиадын амжилтыг харгалзан урамшуулал олгох журам”-ын шалгуурыг хангаж элсэлтийн ерөнхий шалгалтад Математикийн хичээлээр 800 оноо авсан ерөнхий боловсролын Лаборатори “Мэргэд” сургуулийн сурагч Энхжаргалын Энхчимэг, Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн сурагч Батбаатарын Ариунцэцэг, Нийгмийн ухааны хичээлээр 800 оноо авсан Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагч Ирэгжийбуугийн Ундрахжаргал, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагч Дэлгэрсайханы Одгэрэл нарт тус бүр 1,000,000 (нэг сая) төгрөгийн сургалтын төлбөрийн урамшуулал олгосугай.

2.Дээрх зардал 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн мөнгөн урамшууллыг Засаг даргын нөөц сангаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100854